



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баяндэлгэр сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: СБА-2022/38/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Баруун-Урт

2022 он

Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: М.Нарантуяа
Утас: 70518396 Цахим хаяг: narantuyam@audit.gov.mn

Аудитын менежер: Г.Даваа
Утас: 70512123 Цахим хаяг: davaag@audit.gov.mn

Аудитор: Б.Мөнхбамбар
Утас: 70512127 Цахим хаяг: munkhbambarb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт.....	2
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	8
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	9
3. Аудитын тайлан.....	10
3.1 Ерөнхий зүйл.....	10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	10
3.4 Материаллаг байдал	11
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	11
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	12
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	13
3.8 Аудитын гол асуудал	13
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	13
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	13
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	14
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	14
4. Аудитын илрүүлэлт	14
4.1 Албан шаардлага	14
4.3 Зөвлөмж	15
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	15

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

1. Аудитын санал дүгнэлт



**СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

22000 Баруун-Урт сум, Сүхбаатар аймаг
Утас: 70518398, Факс: 70518398
E-mail: Sukhbaatar@audit.gov.mn

А.А.О.О.О. № *71.*
танай _____-ны № _____-т

СҮХБААТАР АЙМГИЙН БАЯНДЭЛГЭР
СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА Ж.АВАА ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баяндэлгэр сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баяндэлгэр сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР *М.Нарантуяа* М.НАРАНТУЯА



2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	62,756,732.00	70,642,587.80
33	АВЛАГА	10,939,043.00	00.00
335	Бусад авлага	10,939,043.00	00.00
3351	Байгууллагаас авах авлага	10,939,043.00	00.00
35	БАРАА МАТЕРИАЛ	51,817,689.00	70,642,587.80
354	Хангамжийн материал	50,037,689.00	68,712,587.80
35410	Бичиг хэргийн материал	645,000.00	645,000.00
35420	Аж ахуйн материал	48,472,689.00	66,421,689.00
35440	Түлш, шатах тослох материал	00.00	725,898.80
35470	Бусад хангамжийн материал	920,000.00	920,000.00
35600	Мал амьтад	1,780,000.00	1,930,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,177,771,110.82	1,362,178,970.46
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,177,771,110.82	1,362,178,970.46
392	Биет хөрөнгө	1,156,036,810.82	1,340,579,370.46
39201	Барилга, байгууламж, орон сууц	523,999,864.20	523,999,864.20
39202	Хуримтлагдсан элэгдэл	-30,964,341.00	-47,941,237.56
39203	Авто-гээврийн хэрэгсэл	160,925,869.00	347,525,869.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-124,104,984.64	-147,271,537.94
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	89,521,098.46	98,240,698.46
39206	Хуримтлагдсан элэгдэл	-33,863,863.31	-47,327,736.65
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	53,985,296.77	53,985,296.77
39208	Хуримтлагдсан элэгдэл	-24,599,482.13	-29,078,724.77
39214	Бусад үндсэн хөрөнгө	1,010,697,218.00	1,114,439,431.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-469,559,864.53	-525,992,552.05
393	Биет бус хөрөнгө	21,734,300.00	21,599,600.00
39301	Програм хангамж	432,100.00	432,100.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-432,100.00	-432,100.00
39303	Бусад биет бус хөрөнгө	21,869,000.00	21,869,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	-134,700.00	-269,400.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,240,527,842.82	1,432,821,558.26
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	7,197,840.00	740,670.30
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	7,197,840.00	740,670.30
413	Өглөг	7,197,840.00	740,670.30
4136	Бусад өглөг	7,197,840.00	740,670.30
41361	Байгууллагад төлөх өглөг	7,195,840.00	738,670.30
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	2,000.00	2,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,233,330,002.82	1,432,080,887.96
51	Засгийн газрын хувь оролцоо	1,233,330,002.82	1,432,080,887.96
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	208,397,879.23	208,397,879.23
51101	Өмч: - төрийн	208,397,879.23	208,397,879.23
512	Хуримтлагдсан үр дүн	801,420,491.25	1,000,171,376.39
51210	Өмнөх үеийн үр дүн	801,420,491.25	801,420,491.25
51220	Тайланг үеийн үр дүн	00.00	198,750,885.14
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	223,511,632.34	223,511,632.34
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,240,527,842.82	1,432,821,558.26

Баяндэлгэр сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Давсны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	936,946,076.00	1,026,904,935.50
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	308,553,671.00	312,771,213.00
120	Нийтлэг татварын бус орлого	304,489,671.00	312,771,213.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	304,489,671.00	312,771,213.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	10,737,000.00	00.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	13,025,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	293,752,671.00	299,746,213.00
122	Тусламжийн орлого	4,064,000.00	00.00
122001	Хандив тусламж /дотоод/	4,064,000.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	628,392,405.00	714,133,722.50
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	91,664,305.00	202,061,322.50
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	00.00	1,000,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрсөнгө,түүнтэй адилгах ангилагдаагүй нөөц хөрөнгөө тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	67,227,000.00	72,698,280.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	21,453,305.00	91,938,542.50
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	2,984,000.00	36,424,500.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	536,728,100.00	512,072,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	536,728,100.00	512,072,400.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	798,807,315.92	828,154,050.36
21	УРСГАЛ ЗАРДАЛ	768,197,884.43	792,821,533.69
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	759,313,582.43	763,738,030.69
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	280,212,519.81	283,027,700.50
210101	Үндсэн цалин	219,145,332.26	198,102,703.00
210102	Нэмэгдэл	38,666,346.55	53,760,187.00
210104	Урамшуулал	220,000.00	6,996,087.50
210105	Гэрээт ажлын хөлс	22,180,841.00	24,168,723.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	33,836,518.17	34,673,864.00
210201	Тэтгэврийн даатгал	21,475,109.76	23,515,612.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,708,651.20	2,745,840.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,694,053.95	2,196,672.00
210204	Ажилүйдийн даатгал	541,291.84	548,068.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,417,411.42	5,667,672.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	18,761,183.10	18,000,199.83
210301	Гэрэл, цахилгаан	10,527,518.00	11,585,847.53
210302	Тулш, халаалт	7,610,434.50	5,814,352.30
210303	Цэвэр, бохир ус	623,230.60	600,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	83,681,027.00	32,301,635.00
210401	Бичиг хэрэг	3,634,650.00	3,369,670.00
210402	Тээвэр, шатахуун	33,993,527.00	26,099,575.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,330,000.00	2,456,390.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	578,300.00	376,000.00
210408	Бараа материал акалсны зардал	43,144,550.00	00.00
2105	Нормативт зардал	1,826,000.00	600,000.00
210502	Хоол, хүнс	1,656,000.00	00.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	170,000.00	600,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,461,100.00	23,912,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	799,000.00	18,250,000.00
210604	Урсгал засвар	4,662,100.00	5,662,000.00
2107	Томилолт, зочны зардал	2,229,850.00	1,722,000.00
210702	Дотоод албан томилолт	2,229,850.00	1,722,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,292,894.00	29,622,796.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,369,000.00	29,123,153.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	540,000.00	00.00
210803	Даатгалын үйлчилгээ	183,500.00	168,575.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	101,500.00	3,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	29,000.00	44,000.00
210807	Газрын төлбөр	69,894.00	253,268.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	00.00	30,300.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	329,012,490.35	339,877,835.36
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	166,547,073.00	223,976,902.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага жийх	1,648,120.00	1,246,980.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хөрсгөдөл	160,817,297.35	114,653,953.36

Баяндэлгэр сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	8,884,302.00	29,083,503.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	8,884,302.00	29,083,503.00
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	6,384,302.00	6,158,603.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	20,124,900.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,500,000.00	2,800,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	30,609,431.49	35,332,516.67
2200	Дотоод эх үүсвэрээр	30,609,431.49	35,332,516.67
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	138,138,760.08	198,750,885.14
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	2,647,454.11	00.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	2,647,454.11	00.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-2,647,454.11	00.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	135,491,305.97	198,750,885.14

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	188,393,879.23	41,950,029.90	697,299,432.47	00.00	927,643,341.60
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	188,393,879.23	41,950,029.90	697,299,432.47	00.00	927,643,341.60
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайланг үеийн үр дүн	00.00	00.00	-21,881,577.90	00.00	-21,881,577.90
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	208,397,879.23	223,511,632.34	801,420,491.25	00.00	1,233,330,002.82
D01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	208,397,879.23	223,511,632.34	801,420,491.25	00.00	1,233,330,002.82
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	208,397,879.23	223,511,632.34	801,420,491.25	00.00	1,233,330,002.82
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайланг үеийн үр дүн	00.00	00.00	198,750,885.14	00.00	198,750,885.14
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	208,397,879.23	223,511,632.34	1,000,171,376.39	00.00	1,432,080,887.96

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	663,252,148.00	733,897,765.50
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	14,801,000.00	13,025,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	10,737,000.00	13,025,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	10,737,000.00	13,025,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	10,737,000.00	00.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	13,025,000.00
122	Тусламжийн орлого	4,064,000.00	00.00
122001	Хандив тусламж /дотоод/	4,064,000.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	648,451,148.00	720,872,765.50
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	111,723,048.00	208,800,365.50
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	00.00	1,000,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	87,285,743.00	72,698,280.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	21,453,305.00	91,938,542.50
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	2,984,000.00	43,163,543.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	536,728,100.00	512,072,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	536,728,100.00	512,072,400.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	626,861,148.00	725,178,165.50
21	УРСГАЛ ЗАРДАЛ	626,861,148.00	725,178,165.50

Баяндэлгэр сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	587,367,414.51	660,762,145.83
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	280,212,519.81	283,027,700.50
210101	Үндсэн цалин	217,299,615.26	198,102,703.00
210102	Нэмэгдэл	38,666,346.55	53,760,187.00
210104	Урамшуулал	220,000.00	6,996,087.50
210105	Гэрээт ажлын хөлс	24,026,558.00	24,168,723.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	33,785,037.60	34,673,864.00
210201	Тэтгэврийн даатгал	21,423,629.19	23,515,612.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,708,651.20	2,745,840.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,694,053.95	2,196,672.00
210204	Ажилгүйдлийн даатгал	541,291.84	548,068.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,417,411.42	5,667,672.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	18,737,633.10	18,726,098.33
210301	Гэрэл, цахилгаан	10,527,518.00	11,585,847.53
210302	Түлш, халаалт	7,610,434.50	6,540,250.80
210303	Цэвэр, бохир ус	599,680.60	600,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	33,721,987.00	34,532,965.00
210401	Бичиг хэрэг	4,094,650.00	3,369,670.00
210402	Тээвэр, шатахуун	26,719,037.00	28,220,905.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,330,000.00	2,566,390.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	578,300.00	376,000.00
2105	Нормативт зардал	2,056,000.00	600,000.00
210502	Хоол, хунс	1,656,000.00	00.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	400,000.00	600,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,611,100.00	25,512,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	949,000.00	18,000,000.00
210604	Урсгал засвар	4,662,100.00	7,512,000.00
2107	Томилолт, зочны зардал	4,143,850.00	1,722,000.00
210702	Дотоод албан томилолт	4,143,850.00	1,722,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,292,894.00	34,407,636.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,369,000.00	33,907,993.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	540,000.00	00.00
210803	Даатгалын үйлчилгээ	183,500.00	168,575.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	101,500.00	3,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	29,000.00	44,000.00
210807	Газрын төлбөр	69,894.00	253,268.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	00.00	30,300.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	204,806,393.00	227,559,882.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	203,003,273.00	226,099,902.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,803,120.00	1,459,980.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	39,493,733.49	64,416,019.67
2132	Бусад урсгал шилжүүлэг	8,884,302.00	29,083,503.00
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	6,384,302.00	6,158,603.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	20,124,900.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,500,000.00	2,800,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	30,609,431.49	35,332,516.67
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	30,609,431.49	35,332,516.67
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	36,391,000.00	8,719,600.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	36,391,000.00	8,719,600.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	36,391,000.00	8,719,600.00
2200	Дотоод эх үүсвэрээр	36,391,000.00	8,719,600.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	36,391,000.00	8,719,600.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-36,391,000.00	-8,719,600.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	527,072,400.00	494,819,706.33
21	УРСГАЛ ЗАРДАЛ	527,072,400.00	494,819,706.33
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	498,714,100.00	466,736,203.33
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	288,797,300.00	275,300,813.00
210101	Үндсэн цалин	203,484,300.00	198,102,703.00
210102	Нэмэгдэл	59,816,200.00	53,760,187.00
210105	Гэрээт ажлын хөлс	25,496,800.00	23,437,923.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	36,482,400.00	34,673,864.00
210201	Тэтгэврийн даатгал	24,809,900.00	23,515,612.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,867,900.00	2,745,840.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,294,400.00	2,196,672.00
210204	Ажилгүйдлийн даатгал	574,000.00	548,068.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,936,200.00	5,667,672.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	19,550,000.00	18,612,631.33
210301	Гэрэл, цахилгаан	10,700,000.00	11,472,380.53
210302	Түлш, халаалт	8,250,000.00	6,540,250.80
210303	Цэвэр, бохир ус	600,000.00	600,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	30,638,500.00	27,686,100.00
210401	Бичиг хэрэг	4,500,000.00	3,015,710.00
210402	Тээвэр, шатахуун	22,122,000.00	22,122,000.00
210403	Шуудан, холбоо, интэрнэтийн төлбөр	2,971,500.00	2,172,390.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,045,000.00	376,000.00
2105	Нормативт зардал	600,000.00	600,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	600,000.00	600,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	18,000,000.00	16,231,600.00
210601	Багаж, техник хэрэгсэл	10,000,000.00	8,719,600.00
210604	Урсгал засвар	8,000,000.00	7,512,000.00
2107	Томилолт, зочны зардал	9,216,000.00	1,722,000.00
210702	Дотоод албан томилолт	9,216,000.00	1,722,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	33,129,900.00	31,881,783.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	31,500,000.00	31,382,140.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	540,000.00	00.00
210803	Даатгалын үйлчилгээ	235,300.00	168,575.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	500,000.00	3,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	46,200.00	44,000.00
210807	Газрын төлбөр	270,000.00	253,268.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	38,400.00	30,300.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	62300000.00	60027412.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	60,800,000.00	58,567,432.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,500,000.00	1,459,980.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	28358300.00	28083503.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	28,358,300.00	28,083,503.00
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	6,433,400.00	6,158,603.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	20,124,900.00	20,124,900.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,800,000.00	1,800,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	527,072,400.00	494,819,706.33
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	527,072,400.00	481,794,706.33
132001	Орон нутгийн төсвөөс	527,072,400.00	481,794,706.33
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	00.00	13,025,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	13,025,000.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	28.00	28.00
620001	Удирдах ажилтан	09.00	09.00
620002	Гүйцэтгэх ажилтан	08.00	08.00
620003	Үйлчлэх ажилтан	11.00	11.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		203,745,542.50
21	УРСГАЛ ЗАРДАЛ		203,745,542.50
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		202,745,542.50
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		7,726,887.50
210104	Урамшуулал		6,996,087.50
210105	Гэрээт ажлын хөлс		730,800.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		113,467.00
210301	Гэрэл, цахилгаан		113,467.00
2104	Хангамж, бараа материалын зардал		6,846,865.00
210401	Бичиг хэрэг		353,960.00
210402	Тээвэр, шатахуун		6,098,905.00
210403	Шуудан, холбоо, интэрнэтийн төлбөр		394,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		18,000,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл		18,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		2,525,853.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		2,525,853.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	167,532,470.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		167,532,470.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	0.00	1,000,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг		1,000,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		1,000,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	0.00	203,745,542.50
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		203,745,542.50
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		1,000,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нооц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		74,382,500.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		91,938,542.50
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		36,424,500.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (II)=(II)-(I)		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баяндэлгэр сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд шилэн данс, тээвэр шатахуун, үндсэн хөрөнгө, түлш халаалтын зардалтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Мөнхбамбар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Г.Даваа, газрын дарга, тэргүүлэх аудитор М.Нарантуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Баяндэлгэр сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 19-ны өдрийн 3/21 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Баяндэлгэр сумын Засаг даргын Тамгын газар нь “Төрийн захиргааны байгууллагын манлайллыг дээшлүүлэх, хууль тогтоомж, Засгийн газар болон Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг орон нутагт хэрэгжүүлэх ажлыг шуурхай зохион байгуулах, удирдлагыг цаг үеэ олсон зөвлөгөө, бүх талын үйлчилгээ, мэдээллээр хангах, иргэдэд төрийн үйлчилгээг хөнгөн шуурхай хүргэхэд оршино.” гэсэн эрхэм зорилготой байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ

илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баяндэлгэр сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны нийт зардлын 827.0 сая төгрөгөөс 2.0 хувиар буюу 16.5 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 11.6 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Баяндэлгэр сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 192.3 сая төгрөгөөр буюу 15 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/сая.төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	10.9	0.0	-10.9
Бараа материал	51.8	70.6	18.8
Үндсэн хөрөнгө	1,177.8	1,362.2	184.4
Нийт хөрөнгө	1,240.5	1,432.8	192.3
Өр төлбөр	7.2	0.7	-6.5
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,233.3	1,432.1	198.8
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,240.5	1,432.8	192.3

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,362.2 сая төгрөг болж 184.4 сая төгрөгөөр өссөн нь үнэ төлбөргүй хүлээн авсан 290.3 сая, урсгал төсвөөс худалдан авалтаар 8.7 сая, нийт 299.0 төгрөгийн хөрөнгө нэмэгдэж, 114.6 сая төгрөгийн элэгдлийн зардлаар буурсан нь нөлөөлсөн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,432.1 сая төгрөг болж 198.8 сая төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн нэмэгдсэн нь нөлөөлсөн байна.

Баяндэлгэр сумын Засаг даргын Тамгын газрын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 90.0 сая төгрөгөөр буюу 9 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нэмэлт санхүүжилтийн орлого байна. Тодруулбал нэмэлт санхүүжилтийн орлого 110.4 сая төгрөгөөр буюу 120 хувиар өсөж, тайлант үед 202.1 сая төгрөг болж нэмэгдсэн нь үр дүнгийн тайлангийн орлого нэмэгдэхэд нөлөөлсөн байна.

Нийт зардал өмнөх оноос 29.3 сая төгрөг буюу 4 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардал байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 625.0 сая төгрөгөөр, нийт зарлагыг 625.0 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 97.9 сая төгрөгөөр бууруулж 527.1 сая төгрөгөөр баталсан байна. Энэ нь 2021 онд ковид-19 гарсантай холбогдуулан улс орон даяар өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн нь нөлөөлсөн байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 8 арга хэмжээг санхүүжүүлэхээр 527.1 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 494.8 сая төгрөгийг урсгал зардалд зарцуулж, 30.3 сая төгрөгийг буцааж төвлөрүүлсэн байна.

Нийт зардлын 527.1 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд дээд шатны төсөв захирагчаас 91.9 сая, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 36.4 сая, ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 74.4 сая, төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив 1.0 сая, нийт 203.7 сая төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс цалин хөлс болон нэмэгдэл урамшил 7.7 сая, гэрэл цахилгаанд 0.1 сая, хангамж, бараа материалын зардал 6.8 сая, эд хогшил, урсгал засварын зардал 18.0 сая, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж 2.5 сая, бараа үйлчилгээний

бусад 167.5 сая, нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал 1.0 сая, нийт 203.7 сая төгрөгийг зарцуулжээ.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Байгууллагын үйл ажиллагааны тасралтгүй байх зарчим, холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээний анхаарал татсан асуудал болон санхүүгийн тайлангийн хойших үйл явдал, бусад асуудлын талаар тодорхойгүй байдал үүсээгүй болно.

Тайлант онд Баяндэлгэр сумын Засаг даргатай гүйцэтгэлийн төлөвлөгөө байгуулж, 1 хөтөлбөрийн 8 арга хэмжээнд зарцуулсан төсвийн гүйцэтгэл хангалттай гэж үнэлсэн байна.

3.8 Аудитын гол асуудал

Баяндэлгэр сумын Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагаа, тайлант хугацаанд гарсан ажил гүйлгээ, үйл явдал болон засаглах эрх бүхий этгээдүүдийн түвшин дэх харилцаатай холбоотой санхүүгийн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх асуудал байхгүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим сайтад мэдээлбэл зохих мэдээллээс 149 мэдээллийг хугацаанд мэдээлсэн байна. Харин таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 6 зарлагын гүйлгээний 152.5 сая, урсгал санхүүжилтийн 17 гүйлгээний 688.5 сая төгрөгийг мэдээлээгүй тул албан шаардлага хүргүүлээ.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцэж байгаа боловч зарим мэдээллийг хангалтгүй байршуулсан гэж дүгнэлээ.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Засгийн газрын 2021 оны 43 дугаар “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” тогтоолоор төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулж, төсөвт зардлыг хэмнэхэд чиглэсэн 9 арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг бүх шатны байгууллагын төсөв захирагч нарт даалгасан байна. Тухайлбал:

- Тогтоолын 1.1-д “Үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй

хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах”

- Тогтоолын 1.8-д “байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээнд 20-иос доошгүй хувийн хэмнэлт гаргах; гэж заасан байна”

Сангийн яамнаас 2022 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн “Тодруулга хүргүүлэх тухай” Н-3/845 дугаар албан бичгийг Үндэсний аудитын газарт ирүүлсэн байна. Тус албан бичигт “Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1-д заасан “үндсэн үйл ажиллагаатай холбоотой зайлшгүй шаардлагатай зардал, төсөл, арга хэмжээ” гэдэгт төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах зорилгоор ажилтан, албан хаагчдад төлж байгаа цалин хөлс, олговор, ажил олгогчоос төлөх нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл, цахилгаан, халаалт, цэвэр, бохир ус, түрээсийн зардал болон байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахтай холбоотой шаардлагатай бусад зардал хамаарна.” гэж тодруулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 0.1 сая төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож бүрэн биелүүлсэн байна.

Хүснэгт 2 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

/сая.төг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	1	0.1	1	0.1	-	-	-
Албан шаардлага	-	-	-	-	-	-	-
Зөвлөмж	-	-	-	-	-	-	-
Нийт дүн	1	0.1	1	0.1	-	-	-

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Баяндэлгэр сумын Засаг даргын Тамгын газрын тайлант оны үйл ажиллагаа, төсвийн гүйцэтгэл, ажил гүйлгээ болон санхүүгийн тайланг тасалбар болгож гаргасан өдрөөс хойших үйл явдлыг шинжилж үзэхэд дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 2 алдаа зөрчил илэрснээс, 1 зөрчилд албан шаардлага, 1 асуудалд зөвлөмж өгсөн.

4.1 АЛБАН ШААРДЛАГА

Шилэн дансны нэгдсэн сайтад оруулах мэдээллээс 841.0 сая төгрөгийн 23 мэдээллийг мэдээлээгүй байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 /тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх;/ 6 дугаар зүйлийн 6.1, 6.2, 6.3, 6.4 дэх заалтуудыг зөрчсөн байна.

4.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг эдийн засгийн өгөөжтэй уялдуулан зөв тогтоогоогүйгээс санхүүгийн тайланд элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн үлдэх өртөггүй 99 ширхэг хөрөнгө бүртгэлтэй байгаа зөрчил нь УСНББОУС 17 Үндсэн хөрөнгийн 67 дугаар зүйлд тусгасан "Хөрөнгийн үлдэх өртөг ба ашиглалтын хугацааг наад зах нь санхүүгийн жил бүрийн эцэст хянаж үзэх ба хэрэв хүлээлт нь өмнөх тооцооллоос өөр байвал уг өөрчлөлтийг УСНББОУС 3 тооцооллын өөрчлөлтийн дагуу тайлагнана" заалттай нийцэхгүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Үндсэн хөрөнгийн эдийн засгийн нас буюу ашиглах хугацааг тухайн хөрөнгийн өгөөжтэй уялдуулан зөв тогтоож, УСНББОУС 17 Үндсэн хөрөнгийн 67 дугаар зүйлийг мөрдөж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Баяндэлгэр сумын Засаг даргын Тамгын газар	2	-	-	-	-	-	1	-	1	-

/сая төгрөгөөр/